СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 08 сарын 26 өдөр Дугаар СХШ-2025/10 Сүхбаатар сум

Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Хяналт шалгалтын дүн

Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн СХШ-2025/23/-ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны 2023 оны 2 дугаар улирлаас 2025 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацааны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн алба нь улсын бүртгэлийн 9056564 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100132055001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100132055401 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны төсвийн орлого, зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Номгон тосгоны захирагч Э.Батсүх, 2-р гарын үсгийг ахлах нягтлан бодогч Д.Одгэрэл нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн алба нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 4, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 8 нийт 13 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

4325001132

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн алба нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

Сайхан сумын ИТХ-ын тогтоолоор тус байгууллагын төсвийг санхүүжүүлэхээр 2023 онд 357,599.6 мянган төгрөг, 2024 онд 512,777.3 мянган төгрөг, 2025 онд 513,470.5 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 1. (мянган төгрөгөөр)

№	Огноо	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү /Үлдэгдэл	Хувь
1	2023	2023 оны 20 тогтоол	357,599.6	289,840.2	67,759.4	81.1
2	2024	2024 оны 19 тогтоол	512,777.3	479,382.3	33,395.0	93.5
3	2025	2024 оны 15 тогтоол	513,470.5	93,978.8		
	2025 -1 улирал		127,105.5	93,978.8	33,126.7	73.9

2024 оны төсөвт орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгосон мөнгөн урамшуулал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал нэмэгдсэн учир батлагдсан төсөв 155,177.7 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн байна.

Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал нэмэгдэж батлагдсан байна.

2.2.2 Төсвийн зардлын гүйцэтгэл:

Хүснэгт 2. (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 оны 1 улирал	
		Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЛИЙН ДҮН	357,599.6	289,840.2	512,777.3	479,382.3	127,105.5	93,978.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,599.6	289,840.2	512,777.3	479,382.3	127,105.5	93,978.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,099.6	288,840.2	447,631.8	414,756.8	126,355.5	93,628.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,102.8	202,500.9	325,552.6	306,649.2	91,756.5	77,450.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,747.4	25,312.6	40,694.1	35,611.4	11,469.7	8,742.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,171.6	13,028.2	17,904.0	15,565.7	6,235.5	5,728.5
2104	Хангамж, бараа материалын зардал	12,480.9	10,742.5	20,634.4	17,359.9	4,537.6	764.0
2105	Норматив зардал	0.00	0.00	4,078.8	2,429.8	947.1	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,662.0	28,480.6	28,297.4	27,654.8	7,000.0	303.8
2107	Томилолт, зочны зардал	3,000.0	3,000.0	3,500.0	3,500.0	890.0	400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,899.9	2,818.0	3,584.6	2,954.4	3,519.1	240.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,035.0	2,957.4	3,385.9	3,031.4	0.0	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,500.0	1,000.0	65,145.5	64,625.5	750.0	350.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,500.0	1,000.0	65,145.5	64,625.5	750.0	350.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357,599.6	289,840.2	512,777.3	479,382.3	127,105.5	93,978.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	233,130.3	289,840.2	512,777.3	479,382.3	127,105.5	93,978.8
320001	Орон нутгийн төсвөөс	233,130.3	289,840.2	512,777.3	479,382.3	127,105.5	93,978.8

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2023 онд 289,840.2 мянган төгрөг буюу 81.1 хувь, 2024 онд 479,382.3 мянган төгрөг буюу 93.5 хувь, 2025 оны 1 улирлын байдлаар 93,978.8 мянган төгрөг буюу 73.9 хувиар тайлагнасан байна.

2023 онд нийт 67,759.4 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 35,601.9 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,434.8 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас 25,500.0 мянган төгрөг, бусад зардлаас 2,222.7 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2024 онд нийт 33,395.0 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 18,903.4 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5,082.7 мянган төгрөг, тогтмол зардал 2,338.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 3,274.5 мянган төгрөг, норматив зардал 1,649.0 мянган төгрөг, бусад зардлаас 2,147.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

2025 оны 1 улирлын байдлаар нийт 33,126.7 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 14,306.4 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,727.3 мянган төгрөг, тогтмол зардал 507.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 3,773.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 6,696.2 мянган төгрөг, томилолт, зочны зардал 490.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлаас 3,279.1 мянган төгрөг, норматив зардал 947.1 мянган төгрөг, бусад зардлаас 400.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд хөдөө аж ахуйн мэргэжилтэний сул орон тооноос шалтгаалж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 3 жил дараалан хэмнэгдсэн, 2024 онд урсгал засварын зардлаас үүсгэсэн хэмнэлт, 2025 онд тайлант жил дуусаагүй, урсгал засварын зардал 1-4 улиралд төсвийн хуваарьт хуваах тавьснаас шалтгаалж зардал тус тус хэмнэгдсэн байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:

Хүснэгт 3. (мянган төгрөгөөр)

	2023 он	2024 он	2025 оны 1 улирал
Өмнөх оны үлдэгдэл	0.0	0.0	0.0
Орлого	1,900.0	336.6	1,175.4
Гүйцэтгэл	1,900.0	336.6	1,000.0
Эцсийн үлдэгдэл	0.0	0.0	175.4

Нэмэлт санхүүжилтийн дансанд:

- 2023 онд дээд шатны удирдлагаас 1,000.0 мянган төгрөг, аймгийн ХГБХХГ-аас 600.0 мянган төгрөг /ахмадын арга хэмжээ зохион байгуулах, үзэсгэлэн худалдааны шатахуун/, Сайхан сумын ИТХ-ын албанаас /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ/ 300.0 мянган төгрөгийн орлого орж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.
- 2024 онд дээд шатны удирдлагаас /үзэсгэлэн худалдааны шатахуун/ 336.6 мянган төгрөгийн орлого орж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.
- 2025 оны 1 улиралд дээд шатны удирдлагаас /үзэсгэлэн худалдаа, ахмадын хүндэтгэл/ 1,175.4 мянган төгрөгийн орлого орж, зориулалтын дагуу зарцуулж, 175.4 мянган төгрөгийн /үзэсгэлэн худалдааны шатахуун/ зардлыг зарцуулаагүй үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Сайхан сумын засаг даргын 2023, 2024, 2025 оны 01 дугаар захирамжаар Номгон тосгоны Захирагчийн цалинг, Номгон тосгоны Захирагчийн 2023, 2024, 2025 оны 01 дугаар захирамжаар захирагчийн албаны ажилтан албан хаагчдын цалинг тус тус шинэчлэн баталсан байна.

Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлын тушаал шийдвэр, цагийн тооцоо, цалингийн нэгдсэн систем, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад алдаа зөрчилгүй байна.

Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолын 4.1 дэх хэсэгт "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг ..... 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай." гэж шинэчлэгдсэн боловч Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар "Сумын Засаг даргын тамгын газар, тосгон, захирагчийн албаны бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" захирамжаар Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны орон тоог 13 баталсан нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

2.4. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтөлсөн байна. Аудитын явцад санхүүгийн ажилтан албан хаагчидтай хамтарч үндсэн хөрөнгийн тооллого, тулган баталгаажуулалт хийсэн.

<u>Үндсэн хөрөнгө:</u>

Хүснэгт 4. (мянган төгрөгөөр)

№	Үндсэн хөрөнгө				
	Огноо	**Эхний үлдэгдэл**	**Орлого**	**Зарлага**	**Эцсийн үлдэгдэл**
1	2023	426,854.5	317,585.9	1,463.5	742,976.9
2	2024	742,976.9	28,746.2	0.0	771,723.1
3	2025 - 1 улирал	771,723.1	0.0	0.0	771,723.1

2023 онд үндсэн хөрөнгийн орлого:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 242,618.0 мянган төгрөгийн, аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 60,000.0 мянган төгрөгийн нийт 302,618.0 мянган төгрөгийн Номгон тосгоны гэр хороолол доторх сайжруулсан сайжруулсан шороон замыг бусад орлогоор,
- Аймгийн ЗДТГ-аас 2,149.3 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютер үнэ төлбөргүй хүлээн авснаар,
- Батлагдсан төсвийн хүрээнд зөөврийн компьютер 1, суурин компьютер 1, өнгөт принтер 3, проектор 1, машин тоног төхөөрөмжийг нийт 11,559.2 мянган төгрөгөөр, сандал 6 ширхэг нийт 1,259.4 мянган төгрөгөөр тус тус худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн зарлага:

- Сайхан сумын ИТХ-ын 2023 оны 29 дугаар тогтоолоор машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын зардлаас нийт 1,463.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

2024 онд үндсэн хөрөнгийн орлого:

- Аймгийн ЗДТГ-аас 2024 онд нийт 8,180.0 мянган төгрөгийн 4 суурин компьютер, нийт 7,011.4 мянган төгрийн 4 камер үнэ төлбөргүй хүлээн авснаар,
- Батлагдсан төсвийн хүрээнд шкаф 4, архивын нягтаршуулсан шүүгээ 2, ширээ 2, шүүгээ 1, цаас зүсэгч 1, баримт үдэгч 1, эргэдэг сандал 1, зурагт 1, шат 1, ус буцалгагч нийт 13,154.8 мянган төгрөгөөр тус тус худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

<u>Бараа материал:</u>

Хүснэгт 5. (мянган төгрөгөөр)

№	Бараа материал				
	Огноо	**Эхний үлдэгдэл**	**Орлого**	**Зарлага**	**Эцсийн үлдэгдэл**
1	2023	1,642.3	23,096.7	23,438.2	1,300.8
2	2024	1,300.8	33,106.8	25,982.5	8,425.1
3	2025 - 1 улирал	8,425.1	2,381.1	2,649.4	8,156.8

2025 оны 1 улирлын байдлаар 2,381.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 2,649.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь баримтаар нотлогдож байна.

2.5. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө

Сайхан сумын Санхүү албаны даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2023 онд дотоод хяналт хийгдсэн ба 2024, 2025 онд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

2.6. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

2024 онд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас нийт 668.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй зөрчил илэрснийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас акт тогтоосон ба актыг бүрэн барагдуулсан байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар 2023 оны 04 сарын 01 өдрөөс 2025 оны 03 сарын 31 өдөр хүртэлх хугацааны санхүүгийн баримтад алдаа зөрчил, дутагдал гараагүй.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Бага" эрсдэлтэйд тооцож дүгнэлээ.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

БИЧСЭН:	ТАНИЛЦСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЛСЫН БАЙЦААГЧ	САЙХАН СУМЫН НОМГОН ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Ц.УРТНАСАН	Д.БАЯРБАТ
	НЯГТЛАН БОДОГЧ
	Д.ОДГЭРЭЛ